



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А105

Эг

Сумын Соёлын төвийн бүтэц,
орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 83 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Сумын Соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт, "Соёлын урлаг биеийн тамир, спортын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батширээт сумын Соёлын төвийн бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц орон тооны дагуу албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж, гэрээ байгуулан үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллахыг Соёлын төвийн дарга (Ч.Болорцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



232501003